

Аудитын код: САГ-2018/121/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Ш.Ичинхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: ichinkhorloosh@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

“Атланта баланс аудит”ХХК Утас: 77111056

Цахим хаяг: atlanta.balance.audit@gmail.com

Улаанбаатар хот



Агуулга

Аудитын гэрчилгээ	2
1 Аудитын тайлан	2
1.1 Оршил.....	2
1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	2
1.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	3
1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	3
1.5 Дотоод хяналт.....	4
1.6 Орлогын гүйцэтгэлийн талаарх тайлбар.....	4
1.7 Шилэн дансны мэдээлэл	4
1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	5
1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
1.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
1.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	6
1.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
1.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	6
1.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	6
2 Менежментийн захидал.....	7
3 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
3.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	12
3.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....	1Error! Bookmark not defined.
3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	1Error! Bookmark not defined.
3.5 Аудит хийгдсэн орлого зардлын төлөвлөгөө ба гүйцэтгэл.....	15



1. АУДИТЫН ТАЙЛАН

1.1 Оршил

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ -ын захирал Б.Баттулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд борлуулсан бүтээгдэхүүний өртгийг илүү тайлагнасан, үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг дахин үнэлэх, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллах талаар зөвлөмжид тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ. /САГ-2018/121/ТӨҮГ/

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, батлагдсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.



Тухайн санхүүгийн тайлан хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 23-нөөс 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 13-нд эцэслэн баталгаажуулж, удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Атланта баланс аудит” ХХК-ны ахлах аудитор А.Дэнсмаа, туслах аудитор Ч.Мягмарсүрэн нар гүйцэтгэж чанарын хяналтыг аудитын менежер Т.Ундармаа хэрэгжүүлж, захирал Г. Жаргал хянан удирдав.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Атланта баланс аудит ХХК-д ирүүлсэн байна.

1.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“ШТН” ТӨААТҮГ газар нь ШШГЕГ-ын даргын 1997.07.10-ны А/93 тоот тушаалаар Мааньт дахь Хорих 415 дугаар ангид ял эдэлж байгаа хоригдлыг ажлын байраар хангах, үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулж байна.

2017 онд шохойн чулуу олборлох цехэд 7-10 хоригдол, шохой шатаах цехэд 20-25 хоригдол бутлуурын цехэд 4-5 хоригдол гарган, ажлын байраар хангаж, хүнд машин механизм болон техник хэрэгслийн засвар үйлчилгээг хэрхэн хийх талаар заан, дадлагажуулж ажилласан байна.


ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ нь шохойн чулуу, шохой, эрдэст нунтаг, замаска, мозайкан чулуу зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх төрийн өмчит үйдвэрийн газар юм.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ нь Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудын хүрээнд үндсэн үйл ажиллагаа явуулж байна.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горимсорил, түүний үр дүн

Аудит хийхдээ Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав. ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ -ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төрийн аудитын байгууллага зарим гүйлгээ ихтэй 5 дансанд аудитын нарийвчилсан горим, сорил 24-ийг гүйцэтгэв.



Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” нь санхүүгийн үйл ажиллагаандаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/194 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн санхүүгийн тайлангаа гаргасан байна.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ -ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулгын аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Unicus” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлангаа гаргасан байна.

1.5 Дотоод хяналт

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.


ШШГЕГ-ын хяналт шалгалтын тасгийн хяналт шинжилгээ үнэлгээ дотоод хяналтын хэлтсээс тодорхой чиг үүргийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулж байна.

1.6 Орлогын гүйцэтгэлийн талаарх тайлбар

2017 онд ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ -ыг борлуулалтын орлого 431.4 сая төгрөг, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 275.5 сая төгрөг, удирдлагын зардал 77.1 сая төгрөг, ашиг 155.9 сая төгрөг, ШШГЕГ-т 50.0 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна. Тайлант онд гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого 364.1 сая төгрөг бүрдүүлж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 266,8 сая төгрөг, үйл ажиллагааны зардал 59.9 сая төгрөг зарцуулж, 13.1 сая төгрөгийн үйл ажиллагааны алдагдалтай ажилласан байна. ШШГЕГ-т гүйцэтгэлийн 35.0 сая төгрөг төвлөрүүлж, 15.0 сая төгрөгийн өглөгтэй байна.

1.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төрийн болон улс, орон нутгийн өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх түүнд олон нийт хяналт тавих



ШШГЕГ-ын “ШТН” ТӨААТҮГ 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан байх, талаар судалж үзэхэд Shilendans.gov.mn сайтад 2017 онд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 122 ажил гүйлгээг оруулсан байна.

1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 2 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд 5 дансанд нийт 24 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр ТАБ-СТА-В-3 маягтаар баримтжуулах үе шатны ажлыг хамруулсан.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ -ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг хэмжээний алдаа илрээгүй байна. Материаллаг бус дараах зөрчилд дараах зөвлөмж өгөв.

Бэлэн бүтээгдэхүүний өртөг тооцох эхэлж авсанаа эхэлж зарлагадах аргыг хэрэгжүүлэх явцдаа материаллаг бус алдаа гаргаж борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 202.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментын захидлаар “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 заалтыг мөрдөж ажиллах.

Тус байгууллагын өмч хамгаалах комиссын 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/06 дугаар тушаалаар ашиглалтын хугацааг сунгасан үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийгдээгүй байна.


Шийдвэрлэсэн нь: Менежментын захидлаар Санхүүгийн тайлагналын бодитой оршин байх батламж мэдэгдэлд нийцүүлж ажиллах.

Худалдан авсан бараа материалын дүнгээс нэмэгдсэн өртгийн албан татварын 10 хувийг тооцож, "ebarimt" цахим бүртгэлээр баталгаажих хүртэл "авлагын түр" дансанд бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментын захидлаар “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 заалтыг мөрдөж ажиллах.

1.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ нь ШШГЕГ-ын 2014 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зааснаар компьютер техник хэрэгслийг, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд “машин тоног төхөөрөмж” ангиллаар бүртгэсэн байна.



1.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ – ын 2017 оны санхүүгийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй асуудал байхгүй болно.

1.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ – ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 4.9 сая төгрөгийн материаллаг бус алдааг менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

1.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд 3 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх оны аудитаар шохойн өртөг 55 хувиар өссөн, экскеваторын ашиглагдах хугацааг 5 жилээр тооцсон, “Хэрэмт цамхаг” ТӨҮГ, “Бүрд сондуул” ХХК –нуудад шохойн борлуулалтын үнийг бууруулсан зэрэг аудитын зөвлөмж өгсөн нь 2017 онд дахин давтагдаагүй ба шохойн борлуулалтын өртөг өмнөх оныхоос 38.1 мянган төгрөгөөр буурсан, экскеваторын ашиглагдах хугацааг 10 жил болгон залруулсан, шохойн борлуулалтын үнийн бодлогыг баримталж ажилласан байна.

1.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Төлөвлөлтийн үе шатанд нийт өртөг, зардлыг суурь болгон материаллаг байдлын түвшинг 329.9 сая төгрөгийн 2 хувиар тооцож 6.6 сая төгрөгөөр тогтоосон.

Үндсэн үйл ажиллагаа нь бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулдаг тул өртөг, зардлыг суурь болгосон.

1.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.



2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



Асуудал 1:

Тэргүүлэх ач холбогдол №1

**Борлуулсан бүтээгдэхүүний
өртөгийн талаар**

ҮАГ-ын ажиглалт

“Монгол ташуур” ХХК-д борлуулсан шохойн чулууны нэгжийн өртөг 14.7 мянган төгрөг байсныг 25.0 мянган төгрөгөөр тооцсон, мөн худалдан авсан бараа материалын нэмэгдсэн өртгийн албан татвар 10 хувийг авлагын түр дансанд бүртгэсэн.

ҮАГ-ын зөвлөмж

“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д. “Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх”, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ.

Эрсдэлүүд

Тайлангийн хугацааны үр дүн өөрчлөгдөх эрсдэл,

Төсвийн захирагчийн хариу

Өртгөө буруу тооцоолсон тул дахин ийм алдаа гаргахгүй. Харилцагч байгууллагууд нь мөнгөн суурийг баримталж, НӨАТ-ын баримт өгдөг.



Асуудал 2:

Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

Тус байгууллагын өмч хамгаалах комиссын 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/06 дугаар тушаалаар ашиглалтын хугацааг сунгасан нийт 133.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийгдээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Санхүүгийн тайлагналын бодитой оршин байх батламж мэдэгдэлд нийцүүлж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ.

Эрсдэлүүд:

Санхүүгийн тайланд хөрөнгө үлдэгдэл өртөггүй байх,

Төсвийн захирагчийн хариу:

2018 онд үлдэгдэл өртөггүй болсон үндсэн хөрөнгүүдийн жагсаалтыг гаргаж, дээд газартаа албан бичгээр хүргүүлж, дахин үнэлгээ хийлгэнэ.




3 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

3.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ШШГЕГ-ын “ШТН” ТӨААТҮГ /төгрөгөөр/2017 оны 12 сарын 31-ны өдөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,239,994.43	10,978,423.39
1.1.2	Дансны авлага	38,914,851.54	73,808,059.54
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	6,519,936.37	4,670,309.10
1.1.4	Бусад авлага	86,616,333.00	56,048,832.98
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	60,424,266.46	78,147,446.56
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,000,000.00	6,712,400.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	205,715,881.80	230,365,471.58
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	202,690,522.90	222,900,493.08
1.2.2	Биет бус хөрөнгө	5,238,948.67	3,835,025.55
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	28,453,016.71	21,188,416.75
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	236,382,488.28	247,923,935.38
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	442,098,370.08	478,289,406.96
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	111,907,515.66	153,263,915.66



2.1.1.2	Цалингийн өглөг	41,226.57	
2.1.1.3	Татварын өр	22,242,103.29	35,001,901.91
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	25,900,769.68	21,106,485.52
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	160,091,615.20	209,372,303.09
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	160,091,615.20	209,372,303.09
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: төрийн	463,909,966.01	463,909,966.01
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-181,903,211.13	194,992,862.14
2.3.11	Эздийн өмчийн дүн	282,006,754.88	268,917,103.87
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	442,098,370.08	478,289,406.96



ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ШШГЕГ-ын “ШТН” ТӨААТҮГ /төгрөгөөр/2017 оны 12 сарын 31-ны өдөр

д/д	Үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	225,545,118.23	364,163,607.28
2	Борлуулалтын өртөг	214,235,129.50	240,126,099.14
3	Нийт ашиг (алдагдал)	11,309,988.73	124,037,508.14
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	55,351.65	243,423.23
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	122,808,916.13	89,818,506.31
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-15,277.73	114,116.25
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	-33,579,915.89	-47,641,850.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-145,038,769.37	-13,065,308.69
19	Орлогын татварын зардал	5,535.16	24,342.32
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-145,044,304.53	13,089,651.01
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-145,044,304.53	-13,089,651.01
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		


01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ШШГЕГ-ын “ШТГ” ТӨААТҮГ /төгрөгөөр/2017 оны 12 сарын 31-ны өдөр

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	137,013,867.72	21,272,076.02	305,624,022.27	-37,365,784.00	426,54,182.01
2	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				506,877.40	506,877.40
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-145,044,304.53	-145,044,304.53
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
9	2016 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	137,013,867.72	21,272,076.02	305,624,022.27	181,903,211.13	282,006,754.88
10	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл					
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-13,089,651.01	-13,089,651.01
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт					
15	Зарласан ногдол ашиг					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
17	2017 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	137,013,867.72	21,272,076.02	305,624,022.27	-194,992,862.14	-268,917,103.87



МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ШШГЕГ-ын “ШТН” ТӨААТҮГ /төгрөгөөр/ 2017 оны 12 сарын 31-ны өдөр

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
1	Үндсэн үйлажиллагааны мөнгөн гүйлгээ	183,771,144.00	338,476,880.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	183,211,144.00	331,565,680.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	560,000.00	6,911,200.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	203,970,524.21	298,481,874.27
	Ажиллагчдад төлсөн	105,293,829.34	107,974,057.49
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,636,272.82	2,761,236.33
	Бараа материал худалдан авахад төлсөн	41,712,163.04	50,686,235.50
	Ашиглалтын зардалд төлсөн	1,949,163.00	5,099,977.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	25,524,880.00	74,440,049.99
	Хүүний төлбөрт төлсөн	10,430,870.83	16,712,028.96
	Татварын байгууллагад төлсөн	273,258.00	268,454.00
	Даатгалын төлбөрт төлсөн	16,150,087.18	40,536,808.00
	Бусад мөнгөн зарлага		
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-20,199,380.21	39,995,005.73
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	42,055,351.65	4,243,423.23
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	42,000,000.00	4,000,000.00
	Хүлээн авсан хүүний орлого	55,351.65	243,423.23
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	18,000,000.00	3,500,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	18,000,000.00	3,500,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

	төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтынүйл ажиллагааны цэвэр мөнгөнгүйлгээний дүн	24,055,351.65	743,423.23
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,000,000.00	35,000,000.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Бусад /Төвлөрүүлэлт/	10,000,000.00	35,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааныцэвэр мөнгөн гүйлгээнийдүн	-10,000,000.00	-35,000,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-6,144,028.56	5,738,428.98
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,384,022.99	5,239,994.43
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,239,994.43	10,978,423.39



3.2 Аудит хийгдсэн 2017 ОНЫ ОРЛОГО ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БА ГҮЙЦЭТГЭЛ

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

ä/ä	Үзүүлэлт	2017 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Борлуулалтын орлого		392227.3	364163.6	-28063.7	92.8
1	Шохойн чулуу	22909.1	203131.5	180222.4	886.7
2	Шохой	272727.3	77904.7	-194822.6	28.6
3	Мозайкан чулууны	12272.7	15254.7	2982.0	124.3
4	Эрдэс нунтаг	72727.3	46012.3	-26715.0	63.3
5	Замаскны бэлдэц	11590.9	21860.4	10269.5	188.6
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		275535.9	240126.1	-35409.8	87.1
1	ББӨ-Шохойн чулуу	20644.4	131709.5	111065.1	638.0
2	ББӨ- Шохой	204925.0	59977.1	-144947.9	29.3
3	ББӨ-Мозайкан чулуу	6939.0	7431.1	492.1	107.1
4	ББӨ-Эрдэс нунтаг	35460.0	27532.6	-7927.4	77.6
5	ББӨ-Замаскны бэлдэц	7567.5	13475.8	5908.3	178.1
Нийт ашиг		155914.1	124037.5	-31876.6	79.6
Нийт удирдлагын зардлын дүн		77181.8	89818.5	12636.7	116.4
Цалин хөлс нэмэгдэл урамшил		58951.8	47309.5	-11642.3	80.3
1	Үндсэн цалин	57285.2	46000.7	-11284.5	80.3
2	Ажил олгогчоос НДШ	1666.6	1308.8	-357.8	78.5
Бараа үйлчилгээний бусад зардал		18230.0	42509.0	24279.0	587.7
3	Бичиг хэрэг	540.0	211.3	-328.7	39.1
4	Тээвэр /шатахуун/	6000.0	3167.5	-2832.5	52.8
5	Шуудан холбоо /ин	240.0	0.0	-240.0	0.0
6	Түлш халаалт	3000.0	2858.2	-141.8	95.3
7	Төрбөр /татвар /жижиг хураамж	0.0	0.0	0.0	0.0
8	Элэгдэлийн зардал	29830.8	29830.8	0.0	100.0
9	Цэвэрлэгээ үйлчилгээний материал	0.0	0.0	0.0	0.0
10	Дотоод томилот	600.0	453.0	-147.0	75.5
11	Биеийн тамир уралдаан тэмцээний зардал	250.0	0.0	-250.0	0.0
12	Албан хаагчдын хоолны зардалд	3000.0	1893.4	-1106.6	63.1
13	Сэлбэг хэрэгсэл, бусад туслах материал	80.0	80.0	0.0	100.0
14	Урсгал засвар	1020.0	678.7	-341.3	66.5
15	Бусад зардал	3500.0	3336.1	-163.9	95.3

